

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн байршил, паркт эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрлийн жагсаалт”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд

Ж.ГАНБААТАР

ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН БАЙРШИЛ, ПАРКТ ЭРХЛЭХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР, ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРЛИЙН ЖАГСААЛТ

Байршил	Үйлдвэрлэлийн салбар (ЭЗБҮАСА-С, D) ¹	Үйл ажиллагааны чиглэл	Бүтээгдэхүүний төрөл
Дорноговь аймгийн Алтанширээ, Өргөн сум /674.4 га газар/;	С-19.Кокс болон газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл	191.коксын зуухны бүтээгдэхүүний үйлдвэрлэл	-кокс, хагас кокс, коксын давирхай, хий, химийн бодис зэрэг коксын зуухны бүтээгдэхүүн.
		192.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл	-хий, шингэн түлш, тос, тосолгооны материал зэрэг газрын тосны бүтээгдэхүүн.
Дорноговь аймгийн Хөвсгөл сум /250 га газар/;	С-20.Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	201.химийн үндсэн бодисууд, бордоо болон азотын нэгдлүүд, үндсэн төлөвтэй хуванцар болон нийлэг резин үйлдвэрлэл	-шингэн болон шахсан хий, үйлдвэрийн хий, будаг, пигмент, органик болон органик бус бодис, нэгдэл, химийн элемент, органик бус хүчил, шүлт, органик болон органик бус бодис, нэгдэл, бүтээгдэхүүн, нэрмэл ус, ханасан, ханаагүй цагариг болон цагариг бус нүүрс устөрөгч, нийлэг ароматик нэгдэл, төмрийн пиритийн исэлдэлтийн бүтээгдэхүүн, дан эсвэл нийлмэл азот, фосфат, калийн бордоо, фосфат, калийн давс, аммиак, азотын болон сульфатын нэгдэл, анхдагч болон нийлэг хуванцар, резин, каучук, каучуктай адил бохь, целлюлоз болон түүний химийн хоёрдогч найрлагатай бүтээгдэхүүн.
Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сум /1217.4 га газар/;		202.химийн бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	-хортон, шавж устгагч, будаг, будаг, лак, паалан, органик гадаргуугийн идэвхт бодис, сүрчиг болон ариун цэврийн бүтээгдэхүүн, цэвэрлэгээний болон өнгөлгөөний бүтээгдэхүүн, шатамхай бүтээгдэхүүн, тэсрэх бодис, фото зургийн болон оношилгооны бэлдмэл, төрөл бүрийн химийн бүтээгдэхүүн
Өмнөговь		203.хиймэл утас үйлдвэрлэл	-нийлэг нарийн олсон утас, судалтай олс, томсон утас.

¹ Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319 / А/160 тоот тушаал

<p>аймгийн Цогтцэций сум /1040 га газар/.</p> <p>Сүхбаатар аймгийн Асгат сум;</p> <p>Говьсүмбэр аймгийн Шивээговь сум.</p>	С-23.Металл бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	239.металл бус эрдэс бүтээгдэхүүний үйлдвэрлэл	галд тэсвэртэй бүтээгдэхүүн, барилгын шавран материал, шаазан болон керамик бүтээгдэхүүн, цемент, шохой, гипс болон тэдгээрээр хийсэн эдлэл, материал, бусад металл бус эрдэс бүтээгдэхүүн.
	С-24. Металл боловсруулах үйлдвэрлэл	241.төмөр болон ган үйлдвэрлэл	-төмөр, ган, ширэм тэдгээрийг хайлш, цутгамал, үртэс, нунтаг, ялтас, гулдмай, цул, тайрдас, хавтан, хуудас, хоолой, утас, гагнасан бүтээгдэхүүн.
		242.үнэт болон өнгөт металлын үйлдвэрлэл	- үнэт болон өнгөт металлын хайлш /алт, мөнгө, цагаан алт болон цагаан алтны бүлгийн металл, зэс, хөнгөнцагаан, хар, цагаан тугалга, цайр, хром, манган, никель гэх мэт/, ялтас, нунтаг, гулдмай, хавтан, хуудас, үнэт болон өнгөт металлын хагас боловсруулсан бүтээгдэхүүн.
		243.металлын цутгамал үйлдвэрлэл	-төмөр, ган, ширэмний цутгамал бүтээгдэхүүн, алт, мөнгө, цагаан алт, титан, зэс, цайр, магни, хөнгөн цагаан зэрэг үнэт болон өнгөт металлын цутгамал бүтээгдэхүүн.
	С-25.Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	251.барилгын зориулалттай металл бүтээгдэхүүн, хадгалах сав, уурын үүсгүүр үйлдвэрлэл	барилгын төмөр сараалж болон төмөр хүрээ болон тэдгээрийн эд анги (цамхаг, хөлөг онгоцны шураг, радио телевизийн антен, тороос, гүүр гэх мэт) үйлдвэрлэл, хадгалах сав, цистерн, эдгээртэй төстэй металл сав, хадгалах сав, тэдгээрийн суурь, уурын үүсгүүр.
		259.бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл; металл бүтээгдэхүүн, эдлэл үйлдвэрлэлийн туслах үйл ажиллагаа	-металлыг давтах, цутгах, хуйлах, нунтаглах, бүрэх аргаар хийсэн төмөр багаж хэрэгсэл, ерөнхий зориулалтын төмөр эдлэл, лааз, хувин, хадаас, боолт, эрэг шураг, ахуйн хэрэглээний металл эдлэл, төмөр арматур, усан онгоцны сэнс, зангуу, төмөр замын зам зэрэг төрөл бүрийн бүтээгдэхүүн.
	С-27.Цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэл	271.цахилгаан хөдөлгүүр, үүсгүүр, хувиргагч, цахилгаан эрчим хүч түгээх болон хянах аппарат хэрэгсэл үйлдвэрлэл	-цахилгаан үүсгэх, хуваарилах, тусгай хувиргах төхөөрөмж, цахилгаан хөдөлгүүр, үүсгүүр, эдгээрийн иж бүрдэл, асаалтын тоног төхөөрөмж, асаалтын самбар, релей болон үйлдвэрлэлийн хяналтын тоног төхөөрөмж.
		272.батарей (зай хураагуур) болон аккумулятор үйлдвэрлэл	-дахин цэнэглэх болон цэнэглэхгүй зай хураагуур, манганы диоксид, мөнгөн усны диоксид, мөнгөний диоксид зэргийг агуулсан гүйдэл үүсгэгч (аккумулятор).
		273.цахилгаан утас, кабель болон утас бүхий хэрэгсэл үйлдвэрлэл	-өгөгдөл, дуу, дүрс дамжуулах зориулалттай шилэн кабель, ган, зэс, хөнгөн цагаанаар хийсэн тусгаарлагчтай утас, кабель, утас бүхий хэрэгсэл.

		274.цахилгаан гэрэлтүүлгийн хэрэгсэл үйлдвэрлэл	-цахилгаан чийдэн, чийдэнгийн хоолой болон түүний бүрдэл хэсэг эд анги (цахилгаан чийдэнгийн хоосон шил орохгүй), суурьтай цахилгаан гэрэл (автомашины гэрэл орохгүй), цахилгаан бус гэрэлтүүлэх хэрэгсэл, суурьтай гэрлийн хэрэгслийн бүрдэл хэсэг (гүйдэл дамжуулагч утас бүхий хэрэгсэл орохгүй).
		275.гэр ахуйн цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	-жижиг цахилгаан хэрэгсэл, гэр ахуйн зориулалттай агааржуулагч, сэнс, тоос сорогч, цахилгаан шат, гэр ахуйн чанах, буцалгах хэрэгсэл, гэр ахуйн зориулалттай угаалгын машин, хөргөгч, босоо болон хайрцган хөлдөөгч болон аяга, таваг угаагч, ус халаагч гэх зэрэг бусад цахилгаан ба цахилгаан бус гэр ахуйн хэрэгсэл, цахилгаан, хий эсвэл бусад түлшний эх үүсвэр бүхий хэрэгсэл.
С-28. Машин, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл		281.ерөнхий зориулалтын машин үйлдвэрлэл	-онгоц, автомашин, мотоциклийн хөдөлгүүрээс бусад хөдөлгүүр, турбин, хийн болон шингэн эрчим хүчээр ажиллах тоног төхөөрөмж, шахуурга, компрессор, цорго, хавхлаг зэрэг бусад төхөөрөмж, холживч, араа, дамжуулах, холбох эд анги, зуух, плитк, шатаах зуух, өргөгч, ачигч төхөөрөмж, цахилгаанаар ажилладаг гар багаж хэрэгсэл, ерөнхий зориулалтын бусад машин, тоног төхөөрөмж.
		282.тусгай зориулалтын машин, тоног төхөөрөмж үйлдвэрлэл	-хөдөө аж ахуй, ойн аж ахуйн машин, тоног төхөөрөмж, металл боловсруулах машин, багаж хэрэгсэл, металлургийн зориулалттай машин, тоног төхөөрөмж, уул уурхайн болон барилгын машин, тоног төхөөрөмж, хүнс, ундаа, тамхины үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж, нэхмэл, хувцас, арьс ширэн бүтээгдэхүүн боловсруулах машин, тоног төхөөрөмж, бусад тусгай зориулалтын машин.
С-29. Моторт авто тээврийн хэрэгсэл, чиргүүл, хагас чиргүүл үйлдвэрлэл		291.моторт авто тээврийн хэрэгсэл үйлдвэрлэл	-арилжааны зориулалттай машин, хөдөлгүүрт бусад машин.
		292.моторт тээврийн хэрэгслийн гадар бие болон тэвш үйлдвэрлэл; чиргүүл ба хагас чиргүүл үйлдвэрлэл	машины гадар бие, бүх төрлийн машин, чиргүүл, хагас чиргүүл, тоноглол, багаж хэрэгсэл, тээврийн хэрэгслийн чингэлэг.
		293.моторт тээврийн хэрэгслийн сэлбэг, эд анги үйлдвэрлэл	-машины төрөл бүрийн эд анги, сэлбэг, машины гадар биеийн эд анги, сэлбэг, машины цахилгааны хэсэг, эд анги, хаалга, цонхны систем, хэмжигч эд анги, цахилгаан хүчдэл зохицуулагч зэрэг.
С-30.Тээврийн хэрэгслийн бусад		301.усан онгоц, завь үйлдвэрлэл	-усан онгоц, хөвөгч байгууламж, завь зэрэг.

тоног төхөөрөмж үйлдвэрлэл	302.төмөр замын зүтгүүр, хөдлөх эд анги үйлдвэрлэл	-бүх төрлийн зүтгүүр, суудлын болон ачааны вагон, трамвай, тэргэнцэр зэрэг хөдлөх болон үл хөдлөх бусад эд анги, тусгай сэлбэг хэрэгсэл зэрэг.
	303.агаарын болон сансрын хөлөг, түүнтэй холбогдох тоног төхөөрөмж үйлдвэрлэл	-иргэний болон ачаа тээврийн, байлдааны, спортын болон бусад зориулалтын онгоц, нисдэг тэрэг, дельтаплан, хөдөлгүүргүй онгоц, агаарын бөмбөлөг, эд анги болон дагалдах хэрэгсэл.
	304.цэргийн зориулалттай тээврийн хэрэгсэл үйлдвэрлэл	-танк, цэргийн хуягласан газар уснаа явагч тээврийн хэрэгсэл, хуягласан байлдааны бусад тээврийн хэрэгсэл.
	305.бусад тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж үйлдвэрлэл	-мотоцикл, унадаг дугуй, тэргэнцэр, гар хөдөлгүүрт тээврийн хэрэгсэл, ердийн хөсгийн тээврийн хэрэгсэл.
С-32.Боловсруулах бусад үйлдвэрлэл	321.үнэт эдлэл, гоёл чимэглэлийн зүйлс, холбогдох эдлэл үйлдвэрлэл	-үнэт эдлэл, гоёл чимэглэлийн зүйлс, холбогдох эдлэл.
D-35.Эрчим хүчний үйлдвэрлэл	351.цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл	-эрчим хүч.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ